

Доктор Алисиа Кампи\*

1992 он гэхэд Монгол орон чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шатандаа орлоо. Дотоод, гадаадын эдийн засагчид энэ үеийг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоонд шилжих явц хэмээн тайлбарлаж байна. Энэхүү дүгнэлтийн мадаг нь монголын эдийн засгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон нүүдлийн аж ахуйн шинж чанарыг хайхраагүйд оршино. Орчин үеийн чөлөөт зах зээлийн хууль нь газар тариалан эрхэлж, басхүү үйлдвэр хөгжсөн, суурьшмал аж амьдралтай барууны орнуудын туршлагаас урган гарсан юм. Зүүн Европ хийгээд ЗХУ-ын баруун хязгаарын улс орны эдийн засаг нь мөн тийм л үндэс суурьтай болой. Зөвлөлт болоод Хятад маягийн төвлөрсөн эдийн засгийг судлаачид аль аль нь суурьшмал аж ахуйн хэвшилд тулгуурласан үзэл бодлоо Монголд тулгаж байна. Нүүдлийн аж төрөл, түүний нөхцөл нь тэр эрдэмтдийн үзэл бодолтой даанч нийцэхгүй билээ. Сэцэн Захчид, Пол Хайерын бичсэн «Монголын соёл хийгээд нийгэм» номд Харвардын профессор Жозеф Флетчерын дурдсанаар: «Үйлдвэрлэл-хөдөө аж ахуйн нийгэмд амьдарч буй ХХ зууныхны хувьд Монголчуудын хэрэгцээ, хомсдлыг ойлгох нь амаргүй, бараг боломжгүй юм» хэмээсэн нь бий.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үйл явцыг чиглүүлэх зорилгоор Монголд томилогдсон барууны мэргэжилтнүүд нүүдлийн аж амьдралд зохицсон эдийн засгийн хөшүүргийг илтэд үл ойшоож байна. Тэд олон арван жил баримталсан үзэл бодолдоо автагдан тус оронд нүүдлийн аж ахуй хөгжих ирээдүй байхгүй мэтээр Монголын удирдагчдад номлож байна. Энэ орны эдийн засгийн архаг ужгийг анагаах цорын ганц зам бол чөлөөт зах зээлийн тогтолцоо хэмээн үзэж байна. Энэ нь нэг талаар зөв мэт боловч нөгөө талаар Монголын нөхцөлд өөрчлөлтийг иймэрхүү арга замаар хийвээс үр дүн дулимаг байх бөгөөд ард түмний баялгийг нэмэгдүүлэх, хувь хүний материаллаг сонирхлыг дэмжих, орлого зарлагыг зохицуулах зэрэг эдийн засгийн онолын үндэслэл нь догма хэвээр үлдэх юм. Энэ нь эдүгээ монголчууд «буруу замаар будаа тээж байна» гэсэн үг биш, харин ч эдийн засгийн эдгээр өөрчлөлт шинэчлэл Монголд амжилттай зөв хэрэглэвэл, хэдийгээр нүүдэлчдийн түүхэн, нандин өв нь социализмын үед хясагдаж хяхагдаж ирсэн ч гэлээ, шинэ тогтолцооны соёл, журам горимд идэвхтэй хэлбэрээ хадгалан үлдэх бололмжийг судлах нь зүйтэй.

Юуны өмнө, Монголын эдийн засгийн өнгөрсөн, одоо үеийг үнэт төрх байдлаас нь нарийвчлан судлах шаардлагатай байна. Эдийн засгийн уламжлалт ийм арга нь газар зүйн нөхцөлөөр тодорхойлогддог гэж ч хэлж болно. Малчин хүний аж амьдрал улирлын чанартай байдаг. Тариачдад тун тааламжтай хаврын улирал гэхэд л малчдын хувьд мал сүргийн өвс тэжээл хомс, цас шороон шуургатай эвгүй цаг юм. «Монголын нийгмийн үндэс нь нүүдэл дээр суурилна. Аж амьд-

Алисиа Кампи— АНУ-Монголын зөвлөх бүлгэмийн ерөнхийлөгч, өмнө нь Улаанбаатарт суугаа АНУ-ын ЭСЯ-нд дипломат алба хашиж байсан

ралынх нь бүхий л тал хоолны дэглэм, хувцас, хунар, орон сууц сэлтийг үзвээс энэ нүүдэллэх шинж чанарт зохицдог. Малын бэлчээрийг сэлгэн солих нь ямагт цогцолбор арга хэмжээ байдаг. Нүүдэлчид таван хошуу мал сүргээ ямар нөхцөлд, ямар нутгаар, хэдий хэр хугацаагаар бэлчээрлүүлэхээ тун сайн мэддэг улс.

Монголчуудын хоол хүнс ч өвөрмөц онцлогтой, газар тариалан эрхэлдэг хүмүүсийнхээс тэс өмнөө юм. Тэдний гол хүнс хоол нь мах, сүүн бүтээгдэхүүн. Шашны ёсноос болоод загас иддэггүй, ногооны төрлийг зөвхөн хотынхон л оросуудын нөлөөгөөр хэрэглэж эхэлсэн байна. Монголчуудын олонх одоо болтол ногоог зөвхөн малын тэжээл мэт үздэг. Цаг уурын хүнд хэцүү байдлаас болоод өөхтэй мах, архийг ихээхэн хэмжээгээр хэрэглэнэ. Иймэрхүү хоол унд эрүүл мэндийн хувьд янз бүрийн үр дагавартай байх нь тодорхой боловч тэдэнд илүү тохиромжтой нь маргаангүй. Иймээс Монголд барууны юм уу Азийн газар тариалан эрхэлдэг орныхны хоох хүнсийг оруулж ирэх нь тийм ч зөв зүйтэй зүйл биш шиг санагдана.

Нүүдэлчдийн хэвшил монголчуудын өөрсдийнх нь ахуй амьдралаас урган гарсан учир суурин газрынхны аж төрөлд хүртэл багагүй нөлөөлсөн нь бий. Хотын ч, хөдөөгийн ч эмэгтэйчүүдийнх нь хөдөлмөр харьцангуй хүнд хүчир юм. Тэд аж амьдралд онцгой үүрэг гүйцэтгэнэ: сааль саах, мал хариулах, үйлдвэр, соёл шинжлэх ухааны салбарт ажиллах гэх зэрэг. Бас хоол унд хийх, үр хүүхдээ асарч хүмүүжүүлэх гээд гэр орны хамаг л ажлыг хариуцна. Монгол эрчүүд нь харьцангуй чөлөө зав ихтэй байдаг болохоор гадаадынхан тэднийг залхуу хойрго хэмээн үздэг. Энэ үзэл нь нүүдэлчдийн хөдөлмөрийн уламжлалт хуваарийг үл ойлгосноос болж гардаг юм. Төвлөрсөн эдийн засгийн тогтолцооны үед бол монгол хүн цагийг баримтлахдаа дэндүү хайнга гэж зарим нь шүүмжилдэг байлаа. Малчин ард бугуйн цаг харах уламжлалгүй гэдэг нь үнэн. Гэвч нүүдэлчид барууныхныг бодвол ертөнцийн цаг, улирал, байгалийн өөрчлөлтийг илүү мэдэрдэг юм. Хот суурин газрынхны дотор ч энэ хэвшил хүчтэй хэвээр байна. Үүнээс үзэхэд, цагийн баримжаа нь олон жилийн туршид тэдний мах цусанд шингэжээ. Монголд аж төрөн буй гадаадынхан монголчуудын маргааш гэдэг нь ирээдүй цагтай холбоотой болохыг ойлгодог буй. Учир хэмээвээс нүүдэлчид ганц нэгээр аж төрөх бөгөөд жирийн монгол хүнд гэр бүлийнхнээ эс тооцвоос өдөр тутам харьцдаг хүн бараг байхгүй, иймээс ч тэд дуу цөөтэй, даруу төлөв байдаг юм. Улс төрийн жагсаал цуглаан дээр хүртэл тэд энэ чанараа хадгалдаг. Харин дуу хуур, найр наадам дээр тэд үнэхээр сэтэл их хөдөлгөм байдаг юм. Монгол хүний даруу зан чанарыг мулгуу буюу идэвхгүй хэмээн үзэж огт болохгүй. Үнэндээ Монголчууд сэтгэлийн асар их тэнхээтэй, эрэгцүүлэл ухаарах их чадвартай, дотроо бодолтой улс бөгөөд Азийн бусад ард түмнээс эрс ялгарна. Тэд их цайлган сэтгэлтэйн улмаас гадаадын хүнд бүдүүлэг мэт харагдавч яг дунд нь амьдарч, мэдэж таньсан нэгэнд сайтар ойлгогддог юм. Нүүдэлчин хүний хувийн энэ чанар нь Монголын зэргэлдээх газар тариалан эрхэлдэг, Азийн бужигнасан хөршөөсөө ихээхэн ялгаатай бүлгээ.

Монгол ахуйн нүүдэлчин чанар нь газар бэлчээр эзэмших гойд чадварыг бий болгожээ. Бэлчээр эзэмшихэд өрсөлдөөн бараг үгүй. Тэдний газар эзэмших сонирхол нь суурин нийгмийнхээс тэс өөр. Чөлөөт зах зээлийн тогтолцооны нэг гол зүйл бол хөдөлшгүй хөрөнгийн арилжаа юм. Барууны эдийн засагчид хувийн өмчийн энэхүү номлолыг бүх нийгэмд үйлчлэх бөгөөд эдийн засгийн гол хүчин зүйл мэт үздэг. Гэтэл Монголын нийгэмд бол ийм загварын газар эзэмшил яагаад ч нийцэхгүй.

Ер түүхнээ Чингис хааны үед Төв Ази болон Барууны худалдаа-

чид монголын нэрийн өмнөөс арилжаа наймаа өрнүүлж байсан байна. Манжийн үед худалдааны эрх нь Хятадын доншуур наймаачдын гарт төвлөрчээ. Сүүлийн үед худалдааны давуу эрхийг Зөвлөлт, Зүүн Европынхон эдэлж байжээ. Үндэсний худалдаагаа монголчууд хэзээ ч тогтмол хийгээд эрх мэдлийн хүрээнд явуулж байсангүй. Саяхан хүртэл Монголимпэкс маягийн төрийн худалдааны томоохон байгууллагууд нь арилжаа наймаанаасаа илүү брокер хэлбэрээр ажиллаж байлаа. Эдгээр байгууллагын худалдааны шийдвэр нь ихэвчлэн улс төрийн товчоо болон Зөвлөлтийн хөндлөнгийн оролцооноос шалтгаалан өөрчлөгдөж байв. Алдагдалтай буюу доогуур үнэлсэн бартер худалдааны хэлбэр давамгайлж байжээ.

Сүүлийн хэдэн зуун жилийн турш худалдааг монголчууд элбэг дэлбэг байдлын эх үүсвэр гэсэн утгаар бус, харин гаднын эрхшээлд орох зам мэтээр ойлгож иржээ. Манжийн үед хятадын наймаачид Монгол ноёдод өндөр хүүтэй мөнгө зээлүүлж, өр шир нь жирийн хүмүүсийн хувьд дааж давшгүй татвар болдог байжээ. Гадаадын капитал ихээр орж ирсний улмаас монголчуудын олонх нь харийн худалдаачдад өр тавьж эхэлжээ. Монголын язгууртнууд мал эдлэлээ даруй ийм байдлаар дэнчин болгож хөрөнгө арвижуулах уламжлалт барилаа хайхрахгүйд хүрчээ. Хэдийгээр монголчуудад худалдаа наймаа хийх шаардлага байсан ч хятадын мөнгө хүүлэгчдийг үзэн яддаг, тэднийг луйварчин мэт ойлгодог болжээ. «Хятадын асуудал» хэмээх зүйл 1921 оны хувьсгалын өмнөх үед Хятадын худалдааны байгууллагын бодлогод ихээхэн хор хөнөөл учруулсан асуудал байжээ. Энэ мэтээс болоод монголчууд арилжаа наймаа төдийлөн таашаадаггүй бөгөөд тэр хандлага нь одоо ч байсаар. Тухайлбал, монгол хүн хувийн хэрэгцээнд мөнгө хүүтэй зээлдүүлэхийг шударга бус гэж үздэг. Энэ сөргүү бодлыг дэгжээсэн зүйлийн нэг нь худалдаа гэдэг бол бусдын эрхшээлд орох улс төрийн нөлөө гэсэн тэдний ойлголт юм.

ЗХУ болон ЭЗХТЗ таран бутарснаар монголчуудын олонх нь өнгөрсөн 10-аад жил, Зөвлөлтийн тусламж, зээлийн бодлогод шүүмжлэлтэй хандаж эхлэв. Тэд өөрсдийгөө гадаад худалдааны хүрээнд мэхлэгдсэн гэж бодож байна. Иймээс ч одоогийн засаг төрийн нэр хүнд бүхий хүмүүс хүртэл гадаад худалдааны шинэ хуулинд тодорхой заалт оруулахаас эмээж бартер худалдаанаас бэлэн мөнгөн тооцоонд шилжих талаар санаачилга гаргахгүй байна. Угтаа тэр нь Монгол орны эдийн засгийн хөгжилд туйлын чухал гадаад худалдааны боломж бүхий үйл ажиллагаа юмсан.

Нүүдэлчдийн дунд солилцооны гол хэлбэр болох бартерын худалдаа эрхэлснээс ихээхэн хожуу эдийн засгийн мөнгөн хэлбэр хөгжжээ. 1925 он хүртэл Монголд өөрийн мөнгөн тэмдэгт байсангүй. Уламжлал ёсоор монголчууд цаасан мөнгөнд итгэж чадахгүй байжээ. Мөнгөн ембүү болон барааг л үнэт цаасны оронд хэрэглэх нь илүү хэмээн үзэж байв. Хэзээнээсээ мөнгө зээлдүүлэгчийг мөнгө хүүлэгч гэж үздэг байж. Монголын банкны тогтолцоог шинэчлэгчид нь иймэрхүү ойлголттой хүмүүсийн дунд л орчин үеийн банкны зээлийн системийг бий болгоно гэдгээ ойлгох ёстой. Нүүдэлчдийн дунд мөнгөн тэмдэгтийн үйлчлэх хүрээ маш хязгаарлагдмал байсныг тэмдэглүүштэй. Төв Азийнхны нэгэн адил Монголын нүүдэлчдийн хувьд хөрөнгө хуримтлуулахын утга нь мөн л мал аж ахуйтай холбоотой тэд ердөө л хоол хүнс, хатуу эдлэл, хогшил олж авах гэх мэт хэрэгцээний улмаас арилжаа солилцоо хийнэ. Нүүдлийн аж ахуйнхан цөөн тооны өмч, хогшил тээж явдагт үүний учир байгаа юм. Талын нүүдэлчид ердийн худалдан авагч биш, тэдний хувьд мөнгө нь өөр маягийн хөрөнгийн хэлбэр юм. Тэд малын гаралтай бүтээгдэхүүнээрээ хувцаслаж, хооллож, гэр орноо

тохижуулж чадах учир зөвхөн зайлшгүй зарим үед л мөнгө үнэ цэнэд хүрнэ.

Өнөөгийн Монголын хүнсний хангамжийн зонхилохыг нь буй болгодгоороо малчин хүн гол хөдөлмөрлөгч хүч юм. Мал хөрөнгөө бэлэн мөнгө болгон хувиргах ганц нэгхэн л шалтгаан тэдэнд бий.

Аж төрөхүйн нүүдлийн хэлбэр нь даруй хэрэглээгээр тодорхойлогддог. Зөвхөн хэрэгцээ гарсан тохиолдолд бараа таваар худалдаж авна. Материаллаг эд хогшил буюу мөнгийг зориулалтаар нь хуримтлуулах шалтаг байхгүй. Нөгөөтэйгүүр, мал-хөрөнгө нь хөдөлгөөнт чанартай, нөөцлөхөд тохиромжтой. Монгол хүн бага насны малаа зарах сонирхолгүй. Баруунд тийм биш. Тэр ч байтугай монголчууд хоол хүнсэндээ ч нас шүд гүйцсэн малаа л хэрэглэдэг. Мал нядлах ямарваа нэгэн онцгой шаардлага гарахгүй л бол малчин хүн хэдэн сар жилээр ч тэсвэрлэж байж чадна. Зах зээлд шилжихүйн монголын эдийн засгийн өвөрмөц хөшүүргийн барууны эдийн засагчид ер ойлгохгүй байна. Мөн хуримтлуулах сонирхол хүн болгонд л байх ёстой гэж тэд зөнгөөрөө бодож байна. Мөнгө нь хэрэглээнд орох ёстой. Гэтэл нүүдэлчдийн амьдралд бол энэ хэрэглээ нь маш хязгаарлагдмал юм. Иймэрхүү олон жишээг харахад эдийн засгийн нийтлэг хэмжүүр нүүдэлчинд тэр болгонд тохирохгүй билээ. Жишээнээс үзэхэд. Хэрвээ мөнгө төгрөг, ажлын өндөр хөлсийг эдийн засгийн гол хүчин зүйлээ болгох юм бол уурхайд голдуу казахууд биш монголчууд ажиллаж байх байсан бизээ.

Барууны эдийн засагчдын олж харахгүй байгаа өөр нэг зүйл бол мал сүргийн тоо хэмжээ хөдөлмөрийн хүний хүчин зүйлийн хоорондын харьцаа юм. Эрс тэс цаг уур, малын хашаа хорооны байнгын хомсдол, мал төллөх үеийн нүсэр хөдөлмөр зэрэг бэрх нөхцөл 24 сүргийн тоо толгой нэмэгдсээр ирсэн билээ. Нүүдэлчдийн тоо цөөрч, тэдний тэн хагас нь цөөн тооны хот суурин газар шингэж байгаа үед, уламжлалт эдийн засгийг ажиллах хүчээр хангах нь амаргүй юм. 4—8 малчин айл нийлж нэгэн хотыг бүрдүүлдэг. Малын толгой 1000 хониноос хэтрэхгүй байх, учир нь бэлчээр, малын тэжээлтэй холбоотой. Сүүн бүтээгдэхүүнийг 5 хошуу малаас авдаг. Өдрийн сааль нь хотынхны сүүний хэрэгцээг хангах уу, эсвэл малчдын хүүхдүүдийн гэдсийг цатгах уу гэдгийг бодуштай.

Монгол судлаачдын анхаарлын төвд байх бас нэгэн зүйл бол мал аж ахуйн уламжлалт арга ажиллагаа, тэдний аж амьдрал юм. Малчин хүний харьцангуй бага орлого нь тэднийг хотын тохилог сууцанд нүүж суух гол шалтгаан болохгүй юм. Энэ шилжин суурьших явц гол төлөв социализмын үед албадлагын хэлбэрээр болсон нь хувьсгалын өмнөх лам нарын сүм хийдэд шавилж байсантай адил юм. Бага балчир хүүхдийг боловсрол олгох нэрийдлээр суурьшмал амьдралд хэвшүүлж байжээ. Гэвч нүүдэлчид дасаж хэвшээгүй хот суурины ажлаас илүүтэйгээр уламжлалт ахуйгаа сонгон үргэлжлүүлсээр байгаа юм.

XX зууны эдийн засагчид Монголын нүүдэлчдийг ранчо буюу эдлэн газрын системд шилжүүлэх тухай явган яриа гаргадаг. Монголчуудын ахуй орчин, нэг нэгээсээ алслагдан орших, түргэн нүүдэллэх, малдаа шим сайтай бэлчээр сонгох зэрэг шалтгаанаас энэ маягийн шинэчлэл төдийлэн дэмжлэг олдохгүй л болов уу. Ер монголын нүүдлийн аж ахуйг суурьшмал хэлбэрт оруулъя гэвээс гаднаас ихээхэн хангамж ивээхгүй л бол бүтэшгүй. Малчин хүн, бэлчээрийн мал аж ахуйг тэжээлийн аж ахуй болгосон нөхцөлд л нүүдлийн хэвшлээсээ татгалзаж болох юм. Гэтэл цаг агаарын хатуу нөхцөлд хэрэгцээт тэжээлээ хэрхэн буй болгох вэ гэдэг томоохон асуулат гарч ирнэ дээ.

Эдлэн газрын тогтолцоог сангийн аж ахуй маягаар шийдвэрлэх гэсэн Монголын засгийн газрын 2011 жилийн оролдлого бүтэхэд нэн

бэрх байсан юм бол дэлхийн II дайны дараах хотын хүн амын өсөлтийг юугаар тайлбарлах вэ? гэж асууна биз.

Үүнийг бичигчийн бие энэхүү хотынхны өсөлтийг XVI—XIX зууны үе дэх буддын шашны хөгжилтэй харьцуулж болно хэмээн санаж байна. Тэр үеийг судалбаас шашны нийгэм нь уламжлалт нүүдлийн аж ахуй дээр бий болсон мөлжигч эдийн засгийн хэлбэр байсан нь тодорхой юм. Социалист монголын хотын ер бус үүргийг шинжлэн үзэхэд дээрхтэй адил дүгнэлт хийж болно. Одоогийн суурин амьдрал, худалдааны өсөлт, хотын тогтмол оршин суугчдын байдал зэрэг нь цөм л сүм хийдийн нийгмээс гаралтай нь ойлгомжтой. 1930-аад онд лам нарын талаар явуулсан бодлогын уршгаар сүм хийдүүдийг устгахад Засгийн газар нь эдгээр төвийг Зөвлөлтөөс зээлдэн авсан захиргааны нүсэр аппаратаар орлуулсан юм. Монголд шашин шүтлэг дахин сэргэж буй явцыг ажиглавал сонирхолтой зүйл бас байна. Тухайлбал, суурин төв нь хүн ам, эдийн засгийн нөөцийг оролцуулан шашны төвтэй өрсөлдөж чадах эсэх, мах, сүүн бүтээгдэхүүн лам хуврагын хэрэгцээнээс үүдэн нэмэгдэх эсэх, эсвэл мал аж ахуйн секторын өсөлтийн хязгаарлалт урьд зууны адил хүнсний хангамжийг хотоос зайлсхийлгэж шашны төв рүү шилжүүлэх эсэх зэргийг дурдаж болно.

1950-аад оны нэгдэлжих хөдөлгөөн хэмээх нь нүүдлийн амьдралыг зөвшөөрснөөрөө илүү амжилтад хүрчээ. Улс төрийн аппарат төвлөрсөн захиргааны бүтцэд тулгуурлан уламжлалт ахуйгаасаа тусгаарлан салжээ. Монгол хотын аж амьдралын хэвшил нь зөвлөлтийн загвар, хэмжүүрийн дагуу тогтов. Гэтэл энэ үеэс л ядуу зүдүү байсан нь одоо хэрнээ үргэлжилсээр байна. Улаанбаатарт төвлөрсөн хүнд суртлын аппаратыг төлөөлөх дээд зиндааны эрдэм боловсрол бүхий нэгэн эмэгтэй хөдөөний малчдаасаа илүүгээр орос болон гаднын хүмүүст дотносдог тухайгаа надад аминчлан өгүүлснээр энэхүү хөндийрөлт илт байлаа.

Өнөөдөр Монгол орон барууны чөлөөт эдийн засгийн мэргэжилтнүүдээс зах зээлд шилжих тоо томшгүй удирдамж авч байна. Үүнийг нь ажиглан харваас арваад жилийн өмнө Монголчуудад зөвлөлтийн мэргэжилтнүүдийн өгсөн зөвлөлгөөнтэй тун ч төстэй санагдана. 1992 онд АНУ-ын тусламжийн байгууллагаас\* зохиосон семинар дээр Зүүн Европын аж үйлдвэр-газар тариалангийн суурин орнуудын эдийн засгийн шилжилтийн туршлагыг Монголынхтой харьцуулан онцлон ярьж байлаа. Тусламжийн программ нь өөрийн байгууллагуудын үйл ажиллагааг аливаа орны бүтцийг сайжруулахад чиглүүлэхдээ зан заншлын онцлогийг бололцон үзэхийг зөвлөдөг юм. Гэвч үнэн хэрэгтээ монголын туйлаас өвөрмөц нүүдлийн аж ахуйн өв уламжлалд иймэрхүү хандлага нийцэхгүй. Семинарын гол анхаарал нь өмч ба харилцааны эрхийн асуудалд чиглэн, өмчийн эрх нь хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлдгийг тэмдэглэж байв. Иймэрхүү дүгнэлт Монгол шиг жижиг оронд тохиромжгүй байх нь магад. Америкийн эдийн засагчид социализмын эдийн засгийг өөрчлөх арга барилд мэргэшсэн хэдий ч Монголын хувьд бол хальт гишгэж болох юм. Учир нь монголын улс төрийн зүтгэлтнүүд ЗХУ, Зүүн Европт боловсрол олсон. Монголын эдийн засаг нь захиргаадалтын төвлөрсөн эдийн засгийн нэгэн загвар мөн гэдгээс үүдэн хялбарчилж байж магадгүй. Семинарын үед монголчууд мэргэжилтний зөвлөснөөр сүүн бүтээгдэхүүний үнийг чөлөөлсөн тухай туршлагаасаа ярьсан юм. Сүүний үнийг 6 сарын хугацаагаар чөлөөлсний дараа хотод тэр үнэ 9 удаа нэмэгдэж, сүүний хэмжээ 2 дахин багасчээ. Иймэрхүү хомсдол нь Засгийн газарт давшгүй дарамт үзүүлжээ. Гэтэл америкийн мэргэжилтнүүд монголчууд программын гүйцэтгэлд алдаа

\* Олон улсын Хөгжлийн Агентлаг

гаргасан, эсвэл сүү үйлдвэрлэгчид бага бүтээгдэхүүнд, их хөлс авч чөлөө цагаа ихэсгэсэн гэж үзжээ. Буруу номлол нь зохисгүй байдалд хүргэсний жишээ энэ биш гэж үү. Зах зээлийн үнийг эс харгалзан үнээгээ өдөр бүр саах хэрэгтэй биз дээ. Хөдөөний саальчид хөдөлмөрийн харамжинд авсан бага сага мөнгөө ашиглах боломжгүй, яагаад гэвэл Засгийн газар нь өргөн хэрэглээний бараагаа хот суурин газраараа түгээдэг. Нөгөө хөдөөнийхэн нь мөнгө олох боломжтой болсон учир сүүгээ орон нутагтаа үлдээн үр хүүхдээ тэжээж байна. Энэ мэтийн үнийн реформын уналт нь нүүдэлчдийн ахуйд үйлчилдэг нарийн хөшүүргийг үл ойлгосноос л шалтгаалж байгаа юм.

Монголын эдийн засгийг төлөвлөхөд учирсан бэрхшээл юунд оршино вэ? Үүнийг бичигч Монголын удирдлагад юуны өмнө, өөрийн орныг чөлөөт зах зээлийн тогтолцоонд оруулахдаа олон талын хөтөлбөрийг авч хэлэлцэн улсынхаа түүхийг харгалзан өөрчлөлт хийх нь зүйтэй болно гэдгийг зөвлөх байна. 1930-аад оны эхэн үед тохиолдсон золгүй явдлыг давтаж, гадаадын эдийн засгийн төлөвлөлтөнд уягдан хавчигдах нь болчимгүй зүйл мөн. Ялангуяа одоо үед монголчууд аливаа зах зээлийн бодлогод итгэлээ түргэн алдаж байгааг Засгийн газар анхаарч эхэллээ. 1935 онд ерөнхий сайд Гэндэн ЗХУ-ын жишээгээр социалист байгуулалтын өндөр хэлбэр болох коммун артелиг механикаар бий болгох асуудлыг буруушааж байсныг эргэн санана уу хэмээн зөвлөмөөр байна. Тэрээр Их хурал дээр Монгол оронд «зүүний нугалаа» явуулах болсон Засгийн газрын шийдвэрийг алдаа хэмээн зоригтой шүүмжилсэн билээ. Гэндэн Засгийн газраас орон нутгийн захиргаанд тавих анхаарал суларч, ард түмний итгэл буурч байгааг дурдаад хүн бүхэн хуулийг өөрт ашигтайгаар хэрэглэж байгааг хэлжээ. Өнөөдөр ч гэсэн монголын дотоод байдал нэг их өөрчлөгдөөгүй гэж зарим нэг нь маргах биз ээ. Өмч хувьчлалын арга хэмжээг хэтрүүлсэн гэж Гэндэн шүүмжилсэн ч түүний «Шинэ бодлого» хэмээх программ нь монгол болон гаднын эдийн засагчдын аль алиных нь судлуштай зүйлийн нэг мөн. Тэрээр маш сул эдийн засгийн үндсэн дээр хамтралжуулах хөдөлгөөн явуулсан өмнөх зүтгэлтнүүдийнхээ программыг үгүйсгэжээ. Түүний Засгийн газар хамтралжуулах шийдвэрийг хүчингүй болон малыг өмчлөх явдлыг түргэсгэх, малын тоог нэмэгдүүлэх зэрэгт татварын хуулийг ашиглажээ. Нүүдлийн аж ахуйн бэлчээрийн газрыг нэмэгдүүлэх, хувийн секторын эзлэх хувь хэдийгээр бага боловч мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, хашаа саравч, ус, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ нь Гэндэнгийн хөтөлбөрт тусгалаа олж, сангийн аж ахуй бий болгох явцыг сайн дурын үндсэн дээр шийдүүлэхээр заажээ. Түүний Засгийн газрын бодлого сүм хийдээ орхисон лам нарыг энэ үйлсэд оролцуулахад туслах чиглэлтэй байжээ. Үүнтэй адил төстэй төлөвлөгөөг өнөөгийн хотын ажилгүйчүүдэд туслалцаа болгон хэрэгжүүлж болох юм. Хөдөөгийн тээвэрлэлтийг сайжруулахын тулд Гэндэн онцгой эрх бүхий «Монголтранс»-ыг тарааж бараа тээвэрлэх шууд хэлцлийг худалдагч байгууллага малчны хооронд сайн дурын үндсэн дээр байгуулжээ. Тэр үед хувийн худалдааг дэмжиж байсан ч зохицуулалттай байжээ. Малчны хэрэгцээний барааг түргэн түгээх шуурхай худалдааны хэлбэрийг шинээр байгуулсан нь чухал байв. Удирдлага, захиргааны зардлыг багасгаж, үнэт цаасны ханш тогтворжжээ. Малчдад олгох зээлийн бүтцэд онцгой анхаарал тавьж, үйлдвэрчний байгууллагаас хөдөлгөөн өрнүүлж, уралдааныг хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанарыг хянахад ашиглажээ. «Шинэ бодлогын» үрээр зүүнтний нугалааны уршгийг түргэн хугацаанд арилгаж чаджээ.

1934—1939 онд малын толгой 5,5 саяар нэмэгдэж, урьдах 3 жилээсээ хавьгүй давж, малын хороо, хашаа саравчийн тоо ихээр нэмэгдэж,

1940 он гэхэд 90 гаруй сайн дурын аж ахуйн байгууллага хөдөө орон нутагт бий болжээ. Мэдээж, өнөөгийн эдийн засгийг төлөвлөдөг хүмүүст Гэндэнгийн бодлогыг судлах нь зөвхөн чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэх боловч энэ нь жинхэнэ монголын өөрийн туршлагад үндэслэсэн жишээ юм. Үүнийг харгалзаж үзвэл нүүдлийн аж ахуй бүхий Монгол орныг төвлөрсөн эдийн засгаас чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх арга замыг олох үйлсэд тус нэмэр болох биз ээ, Захчид, Хайер нарын дурдсанаар, хүнд хэцүү байгалийн нөхцөл, Засгийн газрын хязгаарлагдмал чадавх зэргийг үл харгалзан монголчууд хөгжин дэгжих явцдаа уян хатан бөгөөд дэвшилттэй улс болох нь харагдаж байна.

Сул эдийн засгийн бааз дээр үндэслэсэн нүүдлийн аж ахуй нь хот, үйлдвэр, тээврийн системээ хөгжүүлэхэд учир дутагдалтай нь үнэн. Монголчууд нүүдлийн аж ахуйгаас суурин амьдралд шилжих өөрийн гэсэн сонин хувилбарыг түүхнээ гаргаж ирэх үү, эсвэл өөрийн газар нутаг, цаг агаарт зохицсон нүүдлийн хэлбэрээ чөлөөт зах зээлийн бааз дээр хөгжүүлэх чадвартай байх уу гэдэгт асуудлын гол нь оршиж байна.

Англи хэлнээс орчуулсан  
*Д. Баярсайхан*